



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 1/72

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2017 онд байгуулсан гэрээний 3.1.7 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,3 дах заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өрдийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол улсад "Монгол цэргийн өдөр", "Шинэ үеийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 96 жилийн ой", Дундговь аймагт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба байгуулагдсаны 15 жилийн ойг угтаж аймаг дах үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд марш тактикийн тэмцээн, нэгдсэн тоог зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Цэргийн штабын дарга хурандаа Б.Амаржаргал, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн дарга хошууч Д.Ганболд нарт, хөтөлбөрийн дагуу баярын үеэр зохион байгуулагдах урлаг, спортын арга хэмжээнд бие бүрэлдэхүүнийг идэвхитэй оролцуулахыг ҮАБХТҮБ-ий байгууллагуудын дарга нарт, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга дэд хурандаа А.Буянбаатар, спорт заал, шүүгч нарыг томилон ажиллуулахыг Биеийн тамир, спортын газрын дарга М.Наранбадрах нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Тус ойн баярын үеэр зохион байгуулагдах баярын хөтөлбөрийг хавсралт нэгээр, аймгийн Засаг даргын ивээл дор явагддаг марш тактикийн тэмцээний зардалыг хавсралт хоёроор тус тус баталсугай.

Гурав. Маршийн тэмцээнд шаардагдах 1,468,000 /нэг сая дөрвөн зуун жаран найм мянга / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваад/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ




023330 60

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 112 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 96 ЖИЛИЙН ОЙ, ДУНДГОВЬ АЙМАГТ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА БАЙГУУЛЛАГДСАНЫ 15 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫГ УГТАЖ ЗОХИОН ЯВАГДАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

1	Явагдах арга хэмжээ	Оролцох бүрэлдэхүүн	Хугацаа	Байр	Зохион байгуулагч
А. Спорт тоглоомын тэмцээнүүд					
1	Гар бөмбөгийн тэмцээн	Аймгийн ЗДТГ, ЗХ-ний 278-р байгууламж, ЦГ, ОБГ, Улсын бүртгэл, ШШГА-ШША, Прок-ТХ, ЭМГ,	2017.03.14 09.00	Спорт хорооны заал	ШШГА
2	Сагсан бөмбөгийн тэмцээн		2017.03.15 09.00	Спорт хорооны заал	ОБГ
3	Снукер билльярдын тэмцээн		2017.03.13 10.00	ЦГ-ийн спорт заал	Цагдаагийн газар
4	Ширээний теннисын тэмцээн		2017.03.13 10.00	ЦГ-ийн спорт заал	Тагнуулын хэлтэс
5	Буудлагын тэмцээн		2017.03.16 11.00	Буудлагын талбайд	ЗХ-ний 278-р байгууламж
6	Даамны тэмцээн		2017.03.13 10.00	ШШГА-ШША	ШШГА-ШША
Б. Марш тактикийн тэмцээн					
5	Марш тактикийн тэмцээний нээлт	ЗХ-ний 278-р байгууламж ЦГ, ОБГ,	2017.03.17 10.00	Маршийн талбайд	Цэргийн штаб
6	Марш тактикийн тэмцээн		2017.03.17 11.00		Шүүгчийн бүрэлдэхүүн
В. Нэгдсэн арга хэмжээ					
7	Баярын хурал, шагнал гардуулах ажиллагаа урлагын тоглолт	Байгууллагууд	2017.03.17 16.00	Аймгийн ЗДТГ-ын А заал	ШШГА
8	Нэгдсэн тоо	ҮАБТХЧҮБ байгууллагууд	2017.03.17 19.00	Аймгийн ЗДТГ-ын өмнөх талбайд	Цэргийн штаб ЗХ-ний 278-р байгууламж

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 142 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт



Зардлын задаргаа

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Туяа тоо явуулах талбайн гэрэлтүүлэг, чимэглэл, ёслолын буудлага явуулахад		600.000т
2	Тэргүүний бүтээлч хамт олныг шагнаж урамшуулах		200.000т
3	Тэргүүний жагсаалч хамт олныг шагнаж урамшуулах		200.000т
4	Тэргүүний жагсаалч цэргийн алба хаагч		100.000т
5	Өргөмжлөл	3*40.000т	120.000т
6	Анонс		80.000т
7	Ёслолын ажиллагааны тээврийн зардал	A92*100л, үнэ-1680	168.000т
Бүгд		1,468,000т	

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЕРДЭНЭ